



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/427

Булган сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн шинэчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Д.Алтанзул (ГЭ64102301)-ийн Булган сум 5 дугаар баг Агуулахын товог 2 дугаар гудамж 200 тоотод байршилтай 6308002462 нэгж талбар бүхий гэр, орон сууцны хашааны зориулалтаар эзэмшиж буй 38 м² газар, М.Батмандах (ГЙ91120413)-ийн Булган сум 5 дугаар баг Анхдагчдын өргөн чөлөө 1 дүгээр гудамж 109 тоотод байршилтай 6308003740 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 343 м² газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг тус тус 7 жилээр сунгасугай.

2.Д.Алтанзул, М.Батмандах нарт Булган сумын шинэчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулахыг танилцуулж, газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг иргэн Д.Алтанзул, М.Батмандах нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

8270010404